

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023.02.17	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Ч.ЖАВЗАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар тус байгууллага нь улсын төсвөөс санхүүжихээр батлагдсаны дагуу Эрүүл мэндийн яамны санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлж байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тендерт шалгарсан компанид ажлын гүйцэтгэлийг олгохдоо захиалагчийн техникийн хяналтын зардал 923.4 мянга, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал 461.7 мянга, зураг төсвийн үнэ 1028.4 нийт 2413.5 мянган төгрөгийг гүйцэтгэгч компаниас суутган тооцоогүй, 247.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг гэрээний үнээс илүү үнээр худалдан авсан, тайлант хугацаанд татварын байгууллагаас 5404.9 мянган төгрөгийн авлагатай гарсан, өмч хөрөнгөтэй холбоотой засварын ажлуудад өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй зэрэг зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,907,485,155.3	2,243,014,483.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,721,232.4	352,293,035.7
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,721,232.4	352,293,035.7
31210	Төгрөг	3,721,232.4	352,293,035.7
31211	Төрийн сангийн харилцах	2,293,607.0	352,293,035.7
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,427,625.4	0.0
33	АВЛАГА	2,721,157,169.0	8,595,888.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,719,859,181.0	3,191,000.0
33500	Бусад авлага	1,297,988.0	5,404,888.0
33510	Байгууллагаас авах авлага	1,297,988.0	5,404,888.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,182,606,754.0	1,210,195,126.9
35100	Түүхий эд материал	862,745,494.2	972,811,018.4
35110	Тусгай зориулалттай материал	146,748,426.0	130,875,048.4
35130	Эм боох материал	715,997,068.2	841,935,970.0
35400	Хангамжийн материал	319,861,259.8	237,384,108.6
35410	Бичиг хэргийн материал	1,473,850.0	2,499,120.0
35420	Аж ахуйн материал	14,047,088.2	10,537,520.2
35430	Сэлбэг хэрэгсэл	4,527,709.5	4,138,275.3
35440	Түлш, шатах тослох материал	14,633.0	244,650.0
35450	Барилгын засварын материал	1,616,000.0	1,803,200.0
35460	Хүнсний материал	884,800.0	1,344,590.0
35470	Бусад хангамжийн материал	297,297,179.1	216,816,753.1
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	671,930,433.0
36100	Барааны нөөц	0.0	671,930,433.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,044,781,811.4	18,371,822,648.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,044,781,811.4	18,371,822,648.2
39200	Биет хөрөнгө	15,564,719,689.4	16,899,876,056.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,152,551,520.0	10,096,573,320.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-523,305,916.6	-691,097,383.9
39203	Авто-тээврийн хэрэгсэл	712,300,777.0	869,937,962.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-235,215,435.3	-297,907,948.6
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,165,784,348.4	12,268,317,171.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,947,865,552.2	-5,757,073,095.0
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	591,372,500.0	689,216,090.9
39208	Хуримтлагдсан элэгдэл	-350,902,552.0	-278,090,060.6
39300	Биет бус хөрөнгө	1,480,062,122.0	1,471,946,591.5
39301	Програм хангамж	36,007,022.0	36,007,022.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,769,900.0	-11,885,430.5
39303	Бусад биет бус хөрөнгө	1,447,825,000.0	1,447,825,000.0
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,952,266,966.7	20,614,837,131.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,952,266,966.7	20,614,837,131.8
51	Засгийн газрын хувь оролцоо	20,952,266,966.7	20,614,837,131.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,725,816,344.7	6,725,816,344.7
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,725,816,344.7	6,725,816,344.7
51200	Хуримтлагдсан үр дүн	11,175,627,277.6	11,029,660,765.1
51210	Өмнөх үеийн үр дүн	5,046,595,910.9	11,367,090,600.0
51220	Тайлант үеийн үр дүн	6,129,031,366.8	-337,429,834.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,050,823,344.4	2,859,360,022.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,952,266,966.7	20,614,837,131.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	21,064,595,587.4	14,586,612,370.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,596,990,848.1	3,685,581,321.0
120	Нийтлэг татварын бус орлого	5,596,990,848.1	3,685,581,321.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	214,930,320.0	400,699,881.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,930,320.0	400,699,881.2
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,025,963,524.2	2,737,172,747.7
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,356,097,003.8	547,708,692.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,467,604,739.4	10,901,031,049.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,101,022,557.4	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	621,445,723.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	458,194,834.4	0.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	21,382,000.0	0.0
1330	Төсвийн захирагчдаас	610,000,000.0	0.0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	150,000,000.0	0.0
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	460,000,000.0	0.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,756,582,182.0	10,901,031,049.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,756,582,182.0	10,901,031,049.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,935,564,220.7	14,858,047,091.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,935,564,220.7	14,858,047,091.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,234,442,866.7	14,749,941,811.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,275,216,989.0	6,998,541,801.0
210101	Үндсэн цалин	3,226,970,233.0	3,729,207,166.0
210102	Нэмэгдэл	2,428,213,990.0	2,468,114,524.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,665,000.0	212,202,000.0
210104	Урамшуулал	459,367,766.0	589,018,111.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	827,910,428.8	887,289,778.4
210201	Тэтгэврийн даатгал	578,715,293.2	611,063,028.2
210202	Тэтгэмжийн даатгал	64,464,703.0	71,963,780.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,506,642.7	56,294,223.5
210204	Ажилгүйдлийн даатгал	12,202,163.6	13,436,124.3
210205	Эрүүл мэндийн даатгал	122,021,626.4	134,532,622.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,010,413,463.9	1,107,324,075.2
210301	Гэрэл, цахилгаан	112,183,552.9	129,874,776.2
210302	Түлш, халаалт	682,780,535.0	737,179,523.0
210303	Цэвэр, бохир ус	192,019,376.0	240,269,776.0
210304	Байрны түрээс	23,430,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	312,981,290.2	429,468,263.5
210401	Бичиг хэрэг	34,272,616.0	34,824,590.0
210402	Тээвэр, шатахуун	88,638,561.7	105,636,735.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,800,053.6	13,993,373.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,499,783.0	81,258,008.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	87,770,276.0	193,755,556.6
2105	Нормативт зардал	4,510,611,299.9	3,067,241,483.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,938,890,675.2	2,679,665,013.8
210502	Хоол, хүнс	404,790,169.0	363,377,970.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	166,930,455.7	24,198,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,450,013.1	142,665,134.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	93,000.0	6,255,200.0
210604	Урсгал засвар	79,357,013.1	136,409,934.3
2107	Томилолт, зочны зардал	14,024,000.0	20,322,000.0
210702	Дотоод албан томилолт	14,024,000.0	20,322,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,208,683.0	287,919,063.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,455,741.0	265,903,095.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.0	2,500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,425,598.0	3,200,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.0	2,765,988.0

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.0	333,000.0
210807	Газрын төлбөр	5,791,300.0	5,791,200.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,783,044.0	7,425,780.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,039,626,698.7	1,809,170,212.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,429,829.6	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	1,787,500.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,023,196,869.1	1,807,382,712.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	701,121,354.0	108,105,280.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	701,121,354.0	108,105,280.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	62,133,192.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	638,988,162.0	108,105,280.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,129,031,366.8	-271,434,721.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	65,995,113.5
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.0	65,995,113.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,129,031,366.8	-337,429,834.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,964,612,765.4	14,022,171,846.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	214,930,320.0	404,472,616.2
120	Нийтлэг татварын бус орлого	214,930,320.0	404,472,616.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	214,930,320.0	404,472,616.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,930,320.0	404,472,616.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,749,682,445.4	13,617,699,230.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,102,959,444.4	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	621,445,723.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	460,131,721.4	0.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	21,382,000.0	0.0
1330	Төсвийн захирагчдаас	610,000,000.0	0.0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	150,000,000.0	0.0
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	460,000,000.0	0.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,036,723,001.0	13,617,699,230.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,036,723,001.0	13,617,699,230.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,850,988,033.0	13,210,354,127.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,850,988,033.0	13,210,354,127.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,758,472,033.0	13,101,207,847.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,253,371,497.0	7,003,375,193.2
210101	Үндсэн цалин	2,892,680,621.0	3,602,603,041.0
210102	Нэмэгдэл	2,719,012,002.0	2,594,667,676.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	211,106,822.0	217,121,508.0
210104	Урамшуулал	430,572,052.0	588,982,968.0

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	814,640,073.8	887,379,252.2
210201	Тэтгэврийн даатгал	587,248,006.3	611,152,554.7
210202	Тэтгэмжийн даатгал	57,961,876.0	71,963,780.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	45,821,740.6	56,294,170.8
210204	Ажилгүйдлийн даатгал	11,237,159.4	13,436,124.3
210205	Эрүүл мэндийн даатгал	112,371,291.5	134,532,622.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,010,413,463.9	1,107,324,075.2
210301	Гэрэл, цахилгаан	112,183,552.9	129,874,776.2
210302	Түлш, халаалт	682,780,535.0	737,179,523.0
210303	Цэвэр, бохир ус	192,019,376.0	240,269,776.0
210304	Байрны түрээс	23,430,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	196,362,619.6	254,331,048.0
210401	Бичиг хэрэг	8,339,528.0	11,900,070.0
210402	Тээвэр, шатахуун	84,753,000.0	102,741,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,094,200.6	14,013,373.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	47,993,341.0	64,808,254.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	41,182,550.0	60,868,051.0
2105	Нормативт зардал	3,104,865,949.7	2,689,942,258.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,643,633,200.7	2,287,318,598.4
210502	Хоол, хүнс	407,677,449.0	363,837,760.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	53,555,300.0	38,785,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,111,363.0	819,859,818.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,025,000.0	13,428,985.0
210602	Тавилга	2,320,800.0	695,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,871,000.0	10,830,700.0
210604	Урсгал засвар	72,894,563.0	794,905,133.0
2107	Томилолт, зочны зардал	13,876,000.0	20,322,000.0
210702	Дотоод албан томилолт	13,876,000.0	20,322,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,258,893,098.0	316,886,703.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,223,435,560.0	270,066,095.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.0	2,500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,425,598.0	3,200,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.0	2,466,188.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.0	623,700.0
210807	Газрын төлбөр	5,791,300.0	5,791,200.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,487,640.0	32,239,520.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,937,968.0	1,787,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,937,968.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	1,787,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,516,000.0	109,146,280.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,516,000.0	109,146,280.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	92,516,000.0	109,146,280.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	113,624,732.4	811,817,718.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	109,903,500.0	463,245,915.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,903,500.0	463,245,915.0
2200	Дотоод эх үүсвэрээр	109,903,500.0	463,245,915.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	109,903,500.0	463,245,915.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-109,903,500.0	-463,245,915.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,721,232.4	348,571,803.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	3,721,232.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,721,232.4	352,293,035.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.7	3,050,823,344.4	5,046,595,910.9	14,823,235,599.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,725,816,344.7	3,050,823,344.4	5,046,595,910.9	14,823,235,599.9
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	6,129,031,366.8	6,129,031,366.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.7	3,050,823,344.4	11,175,627,277.6	20,952,266,966.7
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,725,816,344.7	3,050,823,344.4	11,175,627,277.6	20,952,266,966.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	191,463,322.4	191,463,322.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,725,816,344.7	3,050,823,344.4	11,367,090,600.0	21,143,730,289.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	-191,463,322.4	0.0	-191,463,322.4
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-337,429,834.9	-337,429,834.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,725,816,344.7	2,859,360,022.0	11,029,660,765.1	20,614,837,131.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,637,223,800.0	13,673,600,042.9	963,623,757.1	93.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,637,223,800.0	13,673,600,042.9	963,623,757.1	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,463,783,800.0	13,564,453,762.9	899,330,037.1	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,265,316,400.0	7,003,375,193.2	261,941,206.8	96.4
210101	Үндсэн цалин	3,413,725,200.0	3,602,603,041.0	-188,877,841.0	105.5
210102	Нэмэгдэл	3,106,441,200.0	2,594,667,676.2	511,773,523.8	83.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	223,146,000.0	217,121,508.0	6,024,492.0	97.3
210104	Урамшуулал	522,004,000.0	588,982,968.0	-66,978,968.0	112.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	908,164,500.0	887,379,252.2	20,785,247.8	97.7
210201	Тэтгэврийн даатгал	617,551,900.0	611,152,554.7	6,399,345.3	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	72,653,200.0	71,963,780.1	689,419.9	99.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	58,122,500.0	56,294,170.8	1,828,329.2	96.9
210204	Ажилгүйдлийн даатгал	14,530,600.0	13,436,124.3	1,094,475.7	92.5
210205	Эрүүл мэндийн даатгал	145,306,300.0	134,532,622.3	10,773,677.7	92.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,141,687,000.0	1,107,324,075.2	34,362,924.8	97.0
210301	Гэрэл, цахилгаан	137,400,000.0	129,874,776.2	7,525,223.8	94.5
210302	Түлш, халаалт	765,227,200.0	737,179,523.0	28,047,677.0	96.3
210303	Цэвэр, бохир ус	239,059,800.0	240,269,776.0	-1,209,976.0	100.5
2104	Хангамж, бараа материалын зардал	255,265,400.0	258,331,048.0	-3,065,648.0	101.2
210401	Бичиг хэрэг	11,499,200.0	11,900,070.0	-400,870.0	103.5
210402	Тээвэр, шатахуун	99,799,000.0	102,741,300.0	-2,942,300.0	102.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,095,200.0	14,013,373.0	81,827.0	99.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,000,000.0	64,808,254.0	191,746.0	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,872,000.0	64,868,051.0	3,949.0	100.0

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2105	Нормативт зардал	2,816,658,200.0	2,689,942,258.4	126,715,941.6	95.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,296,326,200.0	2,287,318,598.4	9,007,601.6	99.6
210502	Хоол, хүнс	486,512,000.0	363,837,760.0	122,674,240.0	74.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,820,000.0	38,785,900.0	-4,965,900.0	114.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,741,201,900.0	1,262,731,633.0	478,470,267.0	72.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	405,000,000.0	404,995,800.0	4,200.0	100.0
210602	Тавилга	52,000,000.0	52,000,000.0	0.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	32,300,000.0	10,830,700.0	21,469,300.0	33.5
210604	Урсгал засвар	1,251,901,900.0	794,905,133.0	456,996,767.0	63.5
2107	Томилолт, зочны зардал	23,681,500.0	20,322,000.0	3,359,500.0	85.8
210702	Дотоод албан томилолт	23,681,500.0	20,322,000.0	3,359,500.0	85.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	310,021,400.0	333,260,803.0	-23,239,403.0	107.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	263,166,800.0	286,440,195.0	-23,273,395.0	108.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.0	2,500,000.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.0	3,200,000.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,500,000.0	2,466,188.0	33,812.0	98.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	623,700.0	623,700.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	5,791,200.0	5,791,200.0	0.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,239,700.0	32,239,520.0	180.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,787,500.0	1,787,500.0	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,787,500.0	1,787,500.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,440,000.0	109,146,280.0	64,293,720.0	62.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	173,440,000.0	109,146,280.0	64,293,720.0	62.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	173,440,000.0	109,146,280.0	64,293,720.0	62.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,637,223,800.0	14,022,171,846.2	615,051,953.8	95.8
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,235,117,300.0	13,617,699,230.0	-1,382,581,930.0	111.3
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,235,117,300.0	13,617,699,230.0	-1,382,581,930.0	111.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,402,106,500.0	404,472,616.2	1,997,633,883.8	16.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	213,600,000.0	404,472,616.2	-190,872,616.2	189.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,188,506,500.0	0.0	2,188,506,500.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.0	2,293,607.0		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.0	352,293,035.7		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,427,625.4
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,101,531,819.0	1,427,625.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,531,819.0	1,427,625.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,531,819.0	1,427,625.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,101,531,819.0	1,427,625.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,101,531,819.0	1,427,625.4
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,102,959,444.4	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,102,959,444.4	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	621,445,723.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	460,131,721.4	-
131107	Эоүүд мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	21,382,000.0	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,427,625.4	(1,427,625.4)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,427,625.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,427,625.4	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь “Хүний нөөцийн ур чадвар, ёс зүй, манлайлал бүхий хамт олонд тулгуурлан, үйлчилгээний таатай орчинд хоёр дахь шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, ээлтэй, цогц үзүүлэх замаар хонгор нутгийн хөгжил, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ.

- Байгууллагын ажилтан бүр эрүүл энх, ажлын бүтээмж өндөр байж, байгууллагынхаа нэр хүндийг өргөх.
- Ажилтан бүрийн идэвх чармайлт, итгэх итгэл, нэр хүнд, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх хүндэтгэлтэй байх.
- Нэгдмэл удирдлага, арга зүйтэй байх
- Хөгжлийн түүхэн замнал, хуримтлуулсан туршлагад үндэслэн тусламж үйлчилгээ нь нотолгоонд тулгуурласан үйлчлүүлэгч төвтэй, ээлтэй, хүртээмжтэй, аюулгүй байх
- Үйл ажиллагаа нь тогтвортой, үр дүнтэй, нээлттэй байх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нэгдсэн эмнэлгийн даргын 2018 оны 04 дүгээр сарын 27-ний А/111 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 337,429.8 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	1	2	3	4	5	6
А						
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,907,485.2	18.6%	2,243,014.5	10.9%	(1,664,470.7)	-42.6%
Мөнгөн хөрөнгө	3,721.2	0.0%	352,293.0	1.7%	348,571.8	9367.1%
Авлага	2,721,157.2	13.0%	8,595.9	0.0%	(2,712,561.3)	-99.7%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	1,182,606.8	5.6%	1,882,125.6	9.1%	699,518.8	59.2%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,044,781.8	81.4%	18,371,822.6	89.1%	1,327,040.8	7.8%
Үндсэн хөрөнгө	23,105,841.2	110.3%	25,407,876.6	123.3%	2,302,035.4	10.0%
Хуримтлагдсан элэгдэл	(6,061,059.4)	-28.9%	(7,036,053.9)	-34.1%	(974,994.6)	16.1%
Нийт хөрөнгө	20,952,267.0	100.0%	20,614,837.1	100.0%	(337,429.8)	-1.6%
Өр төлбөр	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	20,952,267.0	100.0%	20,614,837.1	100.0%	(337,429.8)	-1.6%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,952,267.0	100.0%	20,614,837.1	100.0%	(337,429.8)	-1.6%

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь тайлант онд үндсэн дансны үлдэгдэл 352,293.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлагнасан байна.

Авлагын дансны үлдэгдэл 8,595.9 мянган төгрөг болж 2,712,561.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үндсэн тусламж үйлчилгээний 828,203.6 мянга, Ковид-19 цар тахлын хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний 1,883,120.0 мянга, PCR шинжилгээний сорьц цуглуулах ажлын 4,106.0 мянга, төлбөрийг нь төр хариуцах эмийн 4,429.5 мянган төгрөгийн авлага нь Нийгмийн даатгалын сангаас орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,210,195.1 мянган төгрөг болж 27,588.4 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал данс 125,938.9 мянга, бичиг хэргийн материал 1025.3 мянган төгрөгөөр нэмэгдэж байгууллагын даргын 2022 оны А/30 дугаар тушаалын дагуу бусад хангамжийн материал данснаас 87,105.8 мянга, тусгай зориулалтын материал данснаас 46,219.4 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 671,930.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэгдсэн эмнэлгийн дотор, мэдрэл, уламжлалтын тасаг болон гал тогооны дотор засварын ажил, мэс заслын вакуум хагалгааны хэсгийн засварын ажил гэрээний дагуу дуусаагүй байгаа тул нөөцийн бараа дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 25,407,876.6 мянган төгрөг болж 2,302,035.4 мянган төгрөгөөр өссөн нь 1,131,216.3 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 2,989,228.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ төлбөргүй хүлээн авсан 2,989,228.0 мянган төгрөгийн хөрөнгө нь Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 2,097,391.7 мянга, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 51,800.0 мянга, НҮБ-ийн хүүхдийн сангаас 47,209.6 мянга, Найдвар түгээе ТББ-аас 294,366.5 мянга, аймгийн онцгой комиссоос 32,613.1 мянган хөрөнгө хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Мөн тайлант онд Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/29 дугаар тогтоолоор Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8 нэр төрлийн 72,352.3 төгрөгийн барилга, 2022.05.25-ны өдрийн 9/27 дугаар тогтоолоор 411 нэр төрлийн 82,603.1 төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах шийдвэр гаргасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 20,614,837.1 мянган төгрөг болж 337,429.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 337,429.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,131,193.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 14,131,193.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,641,152.6 мянган төгрөгөөр

бууруулж 10,490,040.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/552 дугаар тушаалаар нэг удаа тодотгол хийж 14,637,223.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 13,617,699.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон нэмэлт орлогоор 36,903.0 мянга, дээд шатын төсөв захирагчаас 1,787.5 мянга, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого 365,782.1 мянга нийт 14,022,171.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 13,673,600.1 мянган төгрөгийг зарцуулж 352,293.0 мянган төгрөгийг дансны үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,673,600.1 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь урсгал засварын зардлыг 456,996.8 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийг 20,785.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 34,362.9 мянга, хоол хүнсний зардлыг 122,674.0 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	14,637,223.8	13,673,600.1	963,623.7	94.8%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	14,461,996.3	13,562,666.3	899,330.0	93.8%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	173,440.0	109,146.3	64,293.7	62.9%
4	83601 Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	1,787.5	1,787.5	0	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1,427.6 мянган төгрөгийн үлдэгдлийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 763 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 14,882,907.2 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 74,414.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 52,090.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 34,362.9 мянга, дотоод албан томилолтын зардлыг 3,359.5 мянга нийт 37,722.4 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.3“Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл”-д заасан 3,059,417.5 мянган төгрөгийн 12 мэдээлэл, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 11,695,394.6 мянган төгрөгийн 391 мэдээлэл, 6.4.8” Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 623,946.4 мянган төгрөгийн 315 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж аудитаар 29,334.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 546.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 20,251.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 8,535.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснийг байна.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.18-ний өдрийн 318 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	546.9	2	546.9	100.0
Албан шаардлага	2	20,251.6	2	20,251.6	100.0
Зөвлөмж	2	8,535.5	2	8,535.5	100.0
Нийт дүн	6	29,334.0	6	29,334.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдлийг хугацаагаар нь ангилан судалгаа авахад Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар ирсэн 99,750.0 мянга, НҮБ-ийн хүн амын сангаас хандивласан 1,251.5 мянган төгрөгийн өртөг бүхий эм эмнэлгийн хэрэгслийн хугацаа 2023 оны 03 дугаар сард дуусахаар байгаа тул дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

2. Нэгдсэн эмнэлгийн халдвартын эмнэлгийн барилга нь 2012 онд ашиглалтад орсон бөгөөд тухайн барилга нь дулаан алдалт ихтэйн улмаас маш хүйтэн байдаг бөгөөд цаашид дулааны алдагдлыг багасгахын тулд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж байшингийн дулаалгыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 671,930.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Ногоон хөгжлийн гүүр ХХК-иар "Мэс заслын тасаг, вакум мэс заслын өрөөнүүдийн засвар шинэчлэлтийн ажил"-ын зураг төсвийг 3,960.0 мянган төгрөгийн өртөгтэйгээр гүйцэтгүүлсэн бөгөөд нийт ажлын төсөвт зураг төсвийн үнийг оруулж тооцоогүй байна.

2. Тус байгууллага нь өөрийн хөрөнгөөр нэгдсэн эмнэлгийн дотор, мэдрэл, уламжлалтын тасаг болон гал тогооны дотор засварын ажил, мэс заслын вакум хагалгааны хэсгийн засварын ажлыг гүйцэтгэгч компаниудад шилжүүлсэн 667,970.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд ашиглалтад бүрэн хүлээн аваагүй байхад сайжруулалтаар бүртгэсэн байна.

Аудитаар нийт 109,079.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,660.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 29513.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 76,904.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. "Хуучин халдвартын эмнэлгийн барилга болон угаалгын барилга нурааж газар чөлөөлөх" тендерт шалгарсан "Хийморь Орд ХХК"-д ажлын гүйцэтгэлийн 59204.9 мянган төгрөгийг олгохдоо захиалагчийн техникийн хяналтын зардал 923.4 мянга, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал 461.7 мянга, зураг төсвийн үнэ 1028.4 нийт 2413.5 мянган төгрөгийг гүйцэтгэгч компаниас суутган тооцоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 9.15 "Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгыг үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналтын зардал, захиалагчийн хяналт, магадлашгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын зардал, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт нэгбүрчлэн төсвийн зардлыг тооцно", 9.17 "Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн энэ журмын Хавсралт №16-д заасан маягтыг бөглөж олгоно" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Суутган тооцоогүй 2413.5 мянган төгрөгийг Хийморь Орд ХХК-иар төлүүлж, төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын гэрээний үнэтэй тулгахад АйВиКо интернэшнл ХХК-иас 7 дугаар сард худалдан авсан 4 нэр төрлийн эмийг тус бүр 300-400 төгрөгийн нэмэгдэлтэй буюу нийт 247.0 мянган төгрөгийн илүү үнээр худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 247.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 16271.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 13242.1 мянган төгрөгийн шатахуун нийт 29,513.8 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" заалтуудыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын 29513.8 мянган төгрөгийн и баримтыг холбогдох байгууллага аж ахуйн нэгжээр нөхөн шивүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр 5 удаагийн 34962.9 мянган төгрөгийн засварын ажлын гэрээ байгуулсан бөгөөд тухайн ажлыг хүлээн авсан акт үйлдэж, өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлсөн ч дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Нэгдсэн эмнэлгийн даргын 2022.05.06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.1.8 " Зөвлөлийн шийдвэр нь тухайн хуралдааны дэлгэрэхгүй тэмдэглэл, хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдалд өгсөн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал бүхий Дүгнэлт хэлбэрээр баталгаажиж гарна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэгдсэн эмнэлгийн даргын 2022.05.06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.1.8-д заасны дагуу цаашид хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдалд өгсөн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлтийг гаргаж ажиллах.

2. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Зоригт болд ХХК-тай 71500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан ба уг ажил нь тухайн жилийн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, мөн ТЭЗҮ зураг төсөв боловсруулж батлуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 “Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байх, хууль журмыг хэрэгжүүлж ажиллах.

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд татварын байгууллагаас 5404.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын зөрүүг үнэн зөв тооцоолж, тухай бүр нь тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж ажиллан цаашид Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу өр, авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн										
Санхүүгийн тайланд бүртгээгүй	2	671,930.4			2	671,930.4	2	671,930.4		
Дүн	2	671,930.4			2	671,930.4	2	671,930.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр 5 удаагийн 34962.9 мянган төгрөгийн засварын ажлын гэрээ байгуулсан бөгөөд тухайн ажлыг хүлээн авсан акт үйлдэж, өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлсөн ч ӨХЗ-ийн дүгнэлт гаргаагүй байна.	1	0					1	0
"Хуучин халдвартын эмнэлгийн барилга болон угаалгын барилга нурааж газар чөлөөлөх" тендерт шалгарсан "Хийморь Орд ХХК"-д ажлын	1	2,413.5	1	2,413.5				

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

гүйцэтгэлийн 59204.9 мянган төгрөгийг олгохдоо захиалагчийн техникийн хяналтын зардал 923.4 мянга, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал 461.7 мянга, зураг төсвийн үнэ 1028.4 нийт 2413.5 мянган төгрөгийг гүйцэтгэгч компаниас суутган тооцоогүй байна.								
Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын гэрээний үнэтэй тулгахад АйВико интернэшнл ХХК-иас 7 дугаар сард худалдан авсан 4 нэр төрлийн эмийг тус бүр 300-400 төгрөгийн нэмэгдэлтэй буюу нийт 247.0 мянган төгрөгийн илүү үнээр худалдан авсан байна.	1	247.0	1	247.0				
Тайлант хугацаанд татварын байгууллагаас 5404.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь, 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байна.	1	5,404.9					1	5,404.9
Нийт дүн	4	8,065.4	2	2,660.5			2	5,404.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийцлийн аудитын бусад зөрчил								
Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 16271.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 13242.1 мянган төгрөгийн шатахуун нийт 29,513.8 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.	1	29,513.8			1	29,513.8		
Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Зоригт болд ХХК-тай 71500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан ба уг ажил нь тухайн жилийн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, мөн ТЭЗҮ зураг төсөв боловсруулж батлуулаагүй байна.	1	71,500.0					1	71,500.0
Дүн	2	101,013.8			1	29,513.8	1	71,500.0

-----oOo-----